



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/17/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэцэцэг
Утас: 99019943
Цахим хаяг: erdenetsetseg.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Залруулсан алдаа	17
5.2 Төлбөрийн акт	17
5.3 Албан шаардлага	17
5.4 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦГ	Цагдаагийн газар
ХШУДАГ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

1 ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГА Д.МӨНХБОЛД ТАНАА

2023.02.15 № 2/54
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт тайлант онд 506 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 29.7 хувиар өссөн. Үүнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 20.1 хувиар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 49.5 хувиар, залилах гэмт хэрэг 2 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 26.6, хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.3 дахин тус тус өсөж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 50.0 хувиар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 9.5, дээрэмдэх 28.5, хөрөнгө завших 80.0 хувиар, эд хөрөнгө устгах, гэмтээх 33.3 хувиар, олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 77.8 хувиар, эдийн засгийн гэмт хэрэг 50.0 хувиар тус тус буурсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ нь Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн конторын барилгын зураг төсөв, сургалтын төвийн барилгыг гэрээний дагуу хугацаандаа хүлээлгэн өгөөгүйгээс урьдчилж гарсан зардалд бүртгэснээр он дамжсан насжилт өндөртэй авлага өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэнгүй.

021020209

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



X. Бодбаатар Х.БОДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>323,879,013.79</u>	<u>493,184,138.94</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,923,600.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,923,600.00
3121	Төгрөг	-	2,923,600.00
31211	Төрийн сангийн харилцах	-	2,923,600.00
33	АВЛАГА	10,087.00	16,900,414.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	10,087.00	4,107,414.00
335	Бусад авлага	-	12,793,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	12,793,000.00
34	УРЬДЧИЛГАА	54,719,508.00	152,469,508.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	97,750,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	54,719,508.00	54,719,508.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	54,719,508.00	54,719,508.00
35	БАРАА МАТЕРИАЛ	269,149,418.79	320,890,616.94
351	Түүхий эд материал	117,812,273.00	160,237,636.00
35110	Тусгай зориулалттай материал	105,501,393.00	147,071,956.00
35130	Эм боох материал	12,310,880.00	13,165,680.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	300,000.00	2,170,000.00
354	Хангамжийн материал	127,654,396.79	128,853,906.94
35410	Бичиг хэргийн материал	7,162,709.00	13,553,744.00
35420	Аж ахуйн материал	6,777,956.00	6,777,956.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,444,500.00	1,434,500.00
35440	Түлш, шатах тослох материал	26,023,261.75	11,139,436.90
35450	Барилгын засварын материал	5,739,210.00	6,969,410.00
35460	Хүнсний материал	5,651,250.00	1,473,250.00
35470	Бусад хангамжийн материал	74,855,510.04	87,505,610.04
35600	Мал амьтад	23,382,749.00	29,629,074.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,557,445,623.57</u>	<u>3,372,180,131.04</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,557,445,623.57	3,372,180,131.04
392	Биет хөрөнгө	3,348,515,623.57	3,163,250,131.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,991,407,934.63	2,991,407,934.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(213,434,604.52)	(285,597,111.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	661,675,430.72	581,880,630.72
39204	Хуримтлагдсан элэгдэл	(476,013,899.44)	(449,463,869.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	619,298,329.45	671,364,158.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(312,666,526.09)	(414,234,525.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,359,574.69	91,359,574.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(67,189,612.72)	(74,432,694.02)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	43,470,036.00	43,470,036.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	44,635,200.00	44,635,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(34,026,239.15)	(37,139,202.47)

393	Биет бус хөрөнгө	208,930,000.00	208,930,000.00
39301	Програм хангамж	1,772,500.00	1,772,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,772,500.00)	(1,772,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	208,930,000.00	208,930,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,881,324,637.36</u>	<u>3,865,364,269.98</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,881,324,637.36</u>	<u>3,865,364,269.98</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,881,324,637.36	3,865,364,269.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,520,903,037.12	1,520,903,037.12
51101	Өмч: - төрийн	1,520,903,037.12	1,520,903,037.12
512	Хуримтлагдсан үр дүн	1,097,193,965.72	1,081,233,598.34
51210	Өмнөх үеийн үр дүн	1,097,193,965.72	1,097,193,965.72
51220	Тайлант үеийн үр дүн	-	(15,960,367.38)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,263,227,634.52	1,263,227,634.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,881,324,637.36</u>	<u>3,865,364,269.98</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,978,381,114.50	4,339,856,675.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	240,674,309.50	221,710,368.43
120	Нийтлэг татварын бус орлого	240,674,309.50	199,710,368.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,210,816.00	102,855,843.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,698,738.00	87,863,918.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,635,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,512,078.00	6,356,325.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	131,787,080.50	44,641,029.43
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	20,676,413.00	52,213,496.00
122	Тусламжийн орлого	-	22,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	22,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,737,706,805.00	4,118,146,307.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,655,392,500.00	3,932,741,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,655,392,500.00	3,932,741,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,314,305.00	185,405,007.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,524,590.00	185,405,007.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,139,560,105.41	4,355,817,042.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,139,560,105.41	4,355,817,042.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,115,965,518.41	4,313,722,129.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,244,863,986.00	3,474,871,773.82
210101	Үндсэн цалин	1,821,218,672.00	1,737,114,504.82
210102	Нэмэгдэл	1,387,787,814.00	1,727,462,362.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,857,500.00	10,294,907.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,213,542.00	73,938,510.00

210201	Тэтгэврийн даатгал	4,949,092.00	4,411,473.00
210202	Тэтгэмжийн даатгал	550,168.00	940,809.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	433,415.00	450,720.00
210204	Ажилгүйдлийн даатгал	108,353.00	104,454.00
210205	Эрүүл мэндийн даатгал	64,172,514.00	68,031,054.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,639,762.00	119,327,342.00
210301	Гэрэл, цахилгаан	28,809,100.00	28,964,600.00
210302	Түлш, халаалт	53,871,862.00	81,255,000.00
210303	Цэвэр, бохир ус	9,958,800.00	9,107,742.00
2104	Хангамж, бараа материалын зардал	290,848,861.25	209,549,870.85
210401	Бичиг хэрэг	15,438,382.00	17,677,800.00
210402	Тээвэр, шатахуун	198,632,000.00	174,180,747.85
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,556,735.00	9,336,123.00
210404	Ном, хэвлэл	21,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	549,100.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,294,800.00	8,355,200.00
210408	Бараа материал акталсны зардал	55,356,844.25	-
2105	Нормативт зардал	38,769,655.00	39,411,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	377,300.00	2,094,700.00
210502	Хоол, хүнс	37,211,355.00	37,036,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,181,000.00	280,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,103,240.00	34,752,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	618,000.00	362,550.00
210604	Урсгал засвар	71,485,240.00	34,390,150.00
2107	Томилолт, зочны зардал	12,656,200.00	21,406,400.00
210702	Дотоод албан томилолт	12,656,200.00	21,406,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,454,563.00	18,814,954.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	471,264.00	15,456,914.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,715,444.00	1,655,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	385,000.00	492,100.00
210807	Газрын төлбөр	712,408.00	772,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	170,447.00	438,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	290,415,709.16	321,649,278.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,265,865.00	34,463,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,120,411.50	27,854,607.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	254,029,432.66	259,331,321.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,594,587.00	42,094,913.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,060,000.00	13,628,568.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,620,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,440,000.00	13,628,568.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,817,638.00	28,466,345.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,817,638.00	28,466,345.18
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,716,949.00	-

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,716,949.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(161,178,990.91)</u>	<u>(15,960,367.38)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,016,141.03	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	17,016,141.03	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(17,016,141.03)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(178,195,131.94)</u>	<u>(15,960,367.38)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,816,405,543.00</u>	<u>4,214,645,825.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,698,738.00	96,499,518.00
120	Нийтлэг татварын бус орлого	78,698,738.00	96,499,518.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	78,698,738.00	96,499,518.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,698,738.00	87,863,918.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,635,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,737,706,805.00	4,118,146,307.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,655,392,500.00	3,932,741,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,655,392,500.00	3,932,741,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,314,305.00	185,405,007.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,789,715.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,524,590.00	185,405,007.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,811,025,543.00</u>	<u>4,204,297,425.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,811,025,543.00	4,204,297,425.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,790,757,905.00	4,149,956,513.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,244,896,100.00	3,479,450,696.82
210101	Үндсэн цалин	1,821,240,700.00	1,894,757,896.82
210102	Нэмэгдэл	1,387,797,900.00	1,548,350,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,857,500.00	36,342,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,430,200.00	74,003,916.00
210201	Тэтгэврийн даатгал	4,949,092.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	550,168.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	433,415.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	108,353.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	64,389,172.00	74,003,916.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,279,900.00	107,431,342.00
210301	Гэрэл, цахилгаан	28,809,100.00	28,964,600.00
210302	Түлш, халаалт	61,512,000.00	69,359,000.00
210303	Цэвэр, бохир ус	9,958,800.00	9,107,742.00
2104	Хангамж, бараа материалын зардал	191,869,400.00	199,756,795.00

210401	Бичиг хэрэг	15,089,000.00	23,368,015.00
210402	Тээвэр, шатахуун	158,140,000.00	160,579,257.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,560,400.00	9,026,623.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	636,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.00	6,146,000.00
2105	Нормативт зардал	42,638,000.00	37,946,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	1,289,500.00
210502	Хоол, хүнс	40,838,000.00	34,230,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	2,426,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,019,040.00	40,140,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,294,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,000,000.00	3,813,300.00
210604	Урсгал засвар	74,019,040.00	35,032,850.00
2107	Томилолт, зочны зардал	14,470,000.00	21,406,400.00
210702	Дотоод албан томилолт	14,470,000.00	21,406,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,330,000.00	74,647,814.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,305,000.00	71,728,714.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,715,000.00	1,655,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	510,000.00	492,100.00
210807	Газрын төлбөр	800,000.00	772,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,825,265.00	115,173,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,973,265.00	85,540,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,852,000.00	29,633,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,267,638.00	54,340,911.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,450,000.00	25,874,566.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,700,000.00	12,246,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,750,000.00	13,628,566.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,817,638.00	28,466,345.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,817,638.00	28,466,345.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,380,000.00</u>	<u>10,348,400.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,380,000.00	7,424,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,380,000.00	7,424,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,380,000.00	7,424,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,380,000.00	7,424,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,380,000.00)</u>	<u>(7,424,800.00)</u>
8	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,923,600.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,923,600.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,520,903,037.12	1,265,834,697.02	1,272,782,035.16	4,059,519,769.30
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,607,062.50	2,607,062.50
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,520,903,037.12	1,265,834,697.02	1,275,389,097.66	4,062,126,831.80
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(2,607,062.50)	-	(2,607,062.50)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(178,195,131.94)	(178,195,131.94)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,520,903,037.12	1,263,227,634.52	1,097,193,965.72	3,881,324,637.36
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,520,903,037.12	1,263,227,634.52	1,097,193,965.72	3,881,324,637.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,520,903,037.12	1,263,227,634.52	1,097,193,965.72	3,881,324,637.36
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(15,960,367.38)	(15,960,367.38)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,520,903,037.12	1,263,227,634.52	1,081,233,598.34	3,865,364,269.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,002,622,100.00	3,992,138,873.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,002,622,100.00	3,992,138,873.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,981,376,100.00	3,971,976,307.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,479,450,700.00	3,479,450,697.00
210101	Үндсэн цалин	1,894,757,900.00	1,894,757,897.00
210102	Нэмэгдэл	1,548,350,400.00	1,548,350,400.00

210105	Гэрээт ажлын хөлс	36,342,400.00	36,342,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,546,900.00	74,003,916.00
210205	Эрүүл мэндийн даатгал	74,546,900.00	74,003,916.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,617,700.00	107,431,342.00
210301	Гэрэл, цахилгаан	28,964,600.00	28,964,600.00
210302	Түлш, халаалт	69,359,000.00	69,359,000.00
210303	Цэвэр, бохир ус	9,294,100.00	9,107,742.00
2104	Хангамж, бараа материалын зардал	190,508,400.00	190,474,038.00
210401	Бичиг хэрэг	23,384,800.00	23,368,015.00
210402	Тээвэр, шатахуун	151,296,500.00	151,296,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,044,200.00	9,026,623.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	636,900.00	636,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,146,000.00	6,146,000.00
2105	Нормативт зардал	29,618,100.00	29,614,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,289,500.00	1,289,500.00
210502	Хоол, хүнс	25,898,600.00	25,898,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,430,000.00	2,426,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,610,800.00	47,564,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,752,900.00	8,718,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,813,300.00	3,813,300.00
210604	Урсгал засвар	35,044,600.00	35,032,850.00
2107	Томилолт, зочны зардал	21,421,400.00	21,406,400.00
210702	Дотоод албан томилолт	21,421,400.00	21,406,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,219,100.00	19,647,814.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,300,000.00	16,728,714.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,655,000.00	1,655,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	492,100.00	492,100.00
210807	Газрын төлбөр	772,000.00	772,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,383,000.00	2,383,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,383,000.00	2,383,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,246,000.00	20,162,566.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,246,000.00	20,162,566.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,246,000.00	12,246,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	7,916,566.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,002,622,100.00	3,992,138,873.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,932,741,300.00	3,914,783,332.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,932,741,300.00	3,914,783,332.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	69,880,800.00	77,355,541.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,880,800.00	77,355,541.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	231	218

620001	Удирдах ажилтан	02	02
620002	Гүйцэтгэх ажилтан	221	208
620003	Үйлчлэх ажилтан	08	08

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	185,405,007
21	УРСГАЛ ЗАРДАЛ	185,405,007
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	185,405,007
2104	Хангамж, бараа материалын зардал	9,282,757
210402	Тээвэр, шатахуун	9,282,757
2105	Нормативт зардал	8,332,000
210502	Хоол, хүнс	8,332,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,000,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,000,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,790,250
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,540,250
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,250,000
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	185,405,007
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	185,405,007
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	185,405,007
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагдаагийн газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны тогтоол, шийдвэр, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөө, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- ✓ *Засгийн газрын шийдвэр болон харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- ✓ *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

ЦЕГ-ын 2022 оны 11 дугаар сарын 01-ны өдрийн А/293 тоот тушаалаар Цагдаагийн газрыг 231 орон тоотой байхаар баталсан байна. Цагдаагийн газар нь удирдах 2, гүйцэтгэх албан тушаалтан 208, үйлчилгээний 8 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж батлагдсан орон тооноос 13 орон тоогоор дутуу ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ *Төрийн хэмнэлтийн тухай хууль*

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2022 онд хүний эрхийг дээлэн, үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэд технологийн ашиглалтыг нэмэгдүүлэн албан хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалж хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлж ажиллана гэсэн зорил дэшүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган үр дүнг тооцон ажилласан байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн тус цагдаагийн газар энэ онд хийж хэрэгжүүлэхээр 5 зорилт, 41 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнасан байна.

Тус цагдаагийн газрын нийт алба хаагчид гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, биелэлт үр дүнг тооцон тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Захиргааны ерөнхий хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд тус ажлын хэсэг 2 ажлыг төлөвлөн хэрэгжүүлжээ. ХЗЯ-ны дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас тус онд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу ЦЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 02-ны А/61 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, актлах хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагдаагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад **нийцсэн** тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113.7 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2,923.6	2,923.6
Авлага	54,729.6	169,369.9	114,640.3
Бараа материал	269,149.4	320,890.6	51,741.2
Үндсэн хөрөнгө	3,557,445.6	3,372,180.1	(185,265.5)
Нийт хөрөнгө	3,881,324.6	3,865,364.2	(15,960.4)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,881,324.6	3,865,364.2	(15,960.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,881,324.6	3,865,364.2	(15,960.4)

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Зууны гүүр ХХК-тай барилгын зураг төсөв хийлгэх 55.0 сая төгрөг, Пламбинг дэволюмент ХХК-тай сургалтын төв барих барилгын 42.7 сая, нийт 97.7 сая төгрөгийн худалдан авалтын гэрээ хийсэн боловч гэрээний дагуу хугацаандаа хүлээлгэн өгөөгүйгээс урьдчилж гарсан зардлаар бүртгэснээр авлага өссөн байна
- ✓ Бараа материалын дансанд ЦЕГ-аас тусгай зориулалтын 66.6 сая төгрөгийн материал үнэ төлбөргүйгээр бүртгэж авснаар бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.
- ✓ Үндсэн хөрөнгийн зардал ИТХ-ын 68, 77, 87 тоот тогтоолоор үлдэх өртөггүй автомашин акталсантай холбоотой буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,120.8 сая төгрөг, өөрийн орлогоос 70.0 сая төгрөг нийт 4,190.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 188.2 сая төгрөгөөр бууруулж 3932.7 сая төгрөг, өөрийн орлогыг 69.9 сая төгрөг нийт 4002.6 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3932.7 сая төгрөгийг улсын төсвөөс, өөрийн орлогоос 69.9 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3932.7 сая төгрөг санхүүжилт олгож өөрийн орлогоос 87.8 сая төгрөг нийт 4020.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт 28.4 сая төгрөг буцаан төвлөрүүлж 3992.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3992.1 сая төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 10.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70704/80101-Зардал	3,981,376.1	3,971,976.4	9,399.7	98
2	70711/80802-Тэтгэвэр, тэтгэмж	21,246.0	20,162.5	1,083.5	99
ДҮН		4,002,622.1	3,992,138.9	10,483.2	98.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар давсан орлогоос 2.4 сая, гэрээт харуулын цалин 8.8 сая, ЗДТГ-аас 27.3 сая, ИТХ-аас 12.1 сая, ОНХО-аас 4.0 сая, ОНХС-аас 8.0 сая, Хөшөөт хөгжил сангаас 97.7 сая, сургалтын төлбөрөөс 24.9 сая бусад орлогоос 0.4 сая төгрөг нийт 185.8 сая төгрөг бүрдүүлж Цагдаагийн шинэ барилгын зураг хийлгэх 55.0 сая төгрөг, сургалтын төв барих 42.7 сая төгрөг, сургалтын зардалд 21.9 сая төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 12.5 сая төгрөг, хамгаалалтын зардалд 32.5 сая төгрөг, тэрбум иод хөтөлбөрийн хүрээнд 4.0 сая төгрөг, бусад үйл ажиллагааны зардалд 17.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Ахмадын сангийн дансаар 8.6 сая төгрөгийн санхүүжилт ирж ахмадуудад сар шинэ, улсын баяр наадмын хүндэтгэл болох 5.7 сая төгрөг зарцуулж 2.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн хөрөнгө, бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2023 оны 02 дүгээр сарын 08-наас 02 дүгээр сарын 13-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 47/-Б/295 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5353.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 53.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 32.1 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал гараагүй бөгөөд зайлшгүй шаардлагатай галч, үйлчлэгч нарын ажлын хэрэгцээнд 2.3 сая төгрөгийн ажлын хувцас авч бараа материалд бүртгэн авсан байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 21.4 сая төгрөгийн томилолтын зардлыг давхардсан тоогоор 125 албан хаагчид олгосон байна. Энэ нь гүйцэтгэх албан тушаалтан Улаанбаатар хотод мэргэжлийн сургалтад оролцох, албан хаагчид гэмт хэргийн бүсэд ажиллах, хамгаалалтад гарах, хяналт шалгалт хийх зэрэг ажлаар ажилласан байна.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд Хөшөөт хөгжил сангаас 97.7 сая төгрөгийн сургалтын төв барих санхүүжилт ирж ажлаа хугацаандаа хүлээлгэж өгөөгүйгээс санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 152 мэдээллээс хугацаандаа оруулсан 152 мэдээлэл бүрэн оруулж хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд хяналтын цэгт үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын шатахууны зардлын 10.0 сая төгрөг зориулалт бус зарцуулсан, Ковид -19 цар тахлын үеийн сэргээн босголт, хэвийн үйл ажиллагааг хангахад гарах зардлаас тухайн байгууллагад 9.7 сая төгрөгийн энгэрийн тэмдэг өгсөн байгааг орлого аваагүй байгааг 2022 оны 2 сард багтаан удирдлагын тушаал шийдвэр гаргуулан данс бүртгэлд тусгаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 -д “бүх хөрөнгө оруулалт, авлага” бүтгэнэ гэснийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах гэсэн зөвлөмж өгсөн байгааг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	-	-	-	-	
Зөвлөмж	2	19,720.0	2	19,720.0	100
Нийт дүн	2	19,720.0	2	19,720.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 97.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс 97.7 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

5.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд орлого бүрэн тусгаагүй, хөрөнгө оруулалтаар ирсэн санхүүжилтийг авлагаар тусгаж тайлагнаагүй байгаад дараах залруулга хийгдлээ. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.1.1 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

- ✓ Төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэхээр 97.7 сая төгрөг шилжүүлсэн боловч хугацаандаа ажлаа хүлээлгэн өгөөгүйгээс бүртгэлд тусгалгүй орхигдуулсан байгааг залруулж урьдчилж гарсан зардлын авлагаар тусгасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 1.9 сая төгрөгийн 3 зөрчил² илэрснээс 1.9 сая төгрөгийн дахин давтан гаргахгүй байх 3 заалт бүхий зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй

5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй

5.4 Зөвлөмж

5.4.1 Авлагатай холбоотой

Илрүүлэлт: Он дамжсан насжилт өндөртэй хөрөнгийн авлага буураагүй, өглөг авлагын тооцоо хийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Насжилт өндөртэй авлага бууруулж гэрээний үүргийн биелэлтийг тооцож хөрөнгө орлого авах

5.4.2 Орлоготой холбоотой

Илрүүлэлт: Бэлтгэн нийлүүлэгчдийн хоорондын тооцоо зөрүүтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, шатахууны хөнгөлөлт дутуу тооцсон, малын ашиг шимийн тооцоо хийгээгүйтэй холбоотой 1.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Малын ашиг шимийг тооцож орлогыг тайланд тусгаж зарцуулалтад хяналт тавьж ажиллах

5.4.3 Зардалтай холбоотой

Илрүүлэлт: Аж ахуйн нэгж байгууллагуудаас бараа материал худалдан авахдаа и-баримтгүй гүйлгээ хийсэн, суутгаагүй албан татварын тайлан илгээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" Татварын ерөнхий хуулийн 28-р зүйлийн 28.5-д "татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй ажил гүйлгээг хийхгүй байх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөшөөт хөгжил сангаас хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг данс бүртгэлд тусгаагүй нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хэрэгжээгүй /Урьдчилж гарсан зардалд бүртгэх/	1	97.7			1	97.7	1	97.7				
Дүн	1	97.7			1	97.7	1	97.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Он дамжсан насжилт өндөртэй хөрөнгийн авлага буураагүй, өглөг авлагын тооцоо хийлж баталгаажуулаагүй,	1	-					1	-
Бэлтгэн нийлүүлэгчдийн хоорондын тооцоо зөрүүтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, шатахууны хөнгөлөлт дутуу тооцсон, малын ашиг шимийн тооцоо хийгээгүй	1	1,966.5					1	1,966.5
Дүн	2	1,966.5	-	-	-	-	2	1,966.50

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Аж ахуйн нэгж байгууллагуудаас бараа материал худалдан авахдаа и-баримтгүй гүйлгээ хийсэн, суутгаагүй албан татварын тайлан илгээгүй, анхан шатны баримт иж бүрэн биш	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1						1	
Нийт дүн	1						1	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *[Signature]* Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: *[Signature]* А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИНСЭН:

АУДИТОР: *[Signature]* Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ



**ХОВД АЙМГИЙН
ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНТ
ЦАГДААГИЙН ГАЗАР**

Ховд аймэг, Жаргалант сум, Жаргалант баг,
Төв гудамж-1, 84140 Ховд, Утас/Факс: (976) 70194851
Цахим шуудан: khovd.police8@gmail.com
Цахим хуудас: www.khovd.police.gov.mn

2023.08.28 № 13-7/622

танай _____-ны № _____-т

**Г АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Манай байгууллага 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу 9.7 төгрөгний залруулга хийсэн нь үнэн болно.



**ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД
ХУРАНДАА** Д.МӨНХБОЛД

2023470814

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Цагдаагийн газар
Тайланг хугацаа: 2022.01.01-2022.12.31

№	Алсд гүйдсэний архивын идэвхтэй тодруула	Алдаа, зөрчилтэй төм үгтэ	Зөрчсөн хуулийн залт	Мөнгөн дүн	Шалгагач байгууллагын санал, талдвар, холбогдох байгууллага	Аудтын байгууллагаас гаргасан санал шигдвар	Материаллаг эсэх	
							Материаллаг	Материаллаг бус
A	1	3		4	5	7	9	10
1	Үндсэн хөрөнгө	Хөшөөт хөгжил сангаас хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг данс бүртгэлд тусгаагүй нэгтгэн бодох бүртгэлээр тавих хяналт хэрэглээгүй /урьдчилж гарсан зардалд бүртгэх/	Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.3.1-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйцэтгэл, зургуулах, зардал, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг данс бүртгэлд тусгаагүй нэгтгэн бодох бүртгэлээр тавих хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нэгтгэн бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх үйлдвэрт хийдэг" хульзана"	97,750,000	Зөргүүлэх			97,750,000
2	Орлого	Бэлтгэн нийлүүлэгчдийн хоорондын тооцоо зөрүүтэй тооцоо нийлж бэлтгэвчлүүлэгчид шатахууны хөнгөлөлт дутуу тооцсон, малын ашиг шимийн тооцоо хийгээгүй	Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.5-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нэгтгэн бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нэгтгэн бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх үйлдвэрт хийдэг" хульзана"	1,966,500	Зөвлөмж		1,966,500	
3	Аялага	Он дамжсан нэсэмтл өндөртэй хөрөнгийн аялага буураагүй, өглөг аялагын тооцоо хийлж бэлтгэвчлүүлээгүй.	Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохиостой удирдаж аялага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нэгтгэн бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нэгтгэн бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх үйлдвэрт хийдэг" хульзана"		Зөвлөмж			
4	Бараа материал	Аж ахуйн нэгж байгууллагаас бараа материал худалдан авахдаа и-баримтгүй гүйцэтгэл хийсэн, суулгаагүй албан татваргүй талийн илгээгүй	Нэгтгэн бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.1-д "Нэгтгэн бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шавардан гаргуулах" Татварын ерөнхий хуулийн 28-р зүйлийн 28.5-д "татвар төлөгч болгуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвтэж өгөх, эсхүл цахимваар илгээх үүрэгтэй"		Зөвлөмж			
				99,716,500			1,966,500	97,750,000

Болговсруулсан: Аудитор
Анхан шатанд хянасан аудиторын мөхөөрсөн
Хойр дөх шалгагч хянасан Дарга Тэргүү
Аудитын удирдлагын санал

Д.Энхтайвчиг
Д.Цагаасуран
Д.Мөнхболд
З.Баннамж

2023.02.10
2023.02.10
2023.02.10

Аудитын үйлдвэрийн асуудлыг нотлох баримт баримт: Д.Мөнхболд
Дарга
Нэгтгэн бодоч
З.Баннамж

Зөвшөөрөгүй бол шалтгаан:
1066381 1621020029